



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/245

Улаанбаатар хот

Зардал батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3.1.4, 4.7.6 дахь заалт, 2017 оны 20171218179 тоот “Эмнэлгийн багаж ханган нийлүүлэх гэрээ”-г тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эф ай - 21 унтуулгын бодис гаралт хэмжигч багажийг худалдан авахад шаардагдах 5000000 (таван сая) төгрөгийг төсвийн бусад багаж, техник хэрэгслийн ангиллаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.

2. Батлагдсан төсөвт багтаан хэмжигч багажийг худалдан авч, гэрээний биелэлтийг дүгнэснээс хойш ажлын 3 хоног дотор танилцуулахыг Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба /Ж.Баатар/-д үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.НАРАНТУЯА

БАТЛАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.НАРАНТУЯА

БАТЛАВ. "СҮВЭН УУЛ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ш.ШИМБААТАР

ЭМНЭЛГИЙН БАГАЖ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар: СУ/2017/17

2017 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

2017.12.18.17.9

Улаанбаатар хот

Нэг талаас: Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид захиалагч гэх/

Нөгөө талаас: "Сүвэн-Уул" ХХК /цаашид нийлүүлэгч гэх/ нар дор дурдсан зүйлүүдийг харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү гэрээний үндсэн дээр Нийлүүлэгч нь нийт 1 төрлийн FI-21 унтуулгын бодисны гаралт хэмжигч багажийг 5,000,000 /Таван сая/ төгрөгөөр захиалгын дагуу гэрээгээр нийлүүлэх, захиалагч нь захиалсан бараа бүтээгдэхүүнийг хүлээн авч төлбөрийг хугацаанд нь төлөх үүргийг тус тус хүлээнэ.
- 1.2 Талууд энэхүү гэрээний дагуу ажиллахдаа Монгол Улсын хууль тогтоомжийг дээдлэн, гэрээний заалт бүрийг дагаж мөрдөнө.
- 1.3 Талууд гэрээг харилцан зөвшөөрч гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан өдрөөс хүчинтэйд тооцно.
- 1.4 Гэрээг 2 хувь үйлдэж талууд нэг нэг хувийг хадгалж мөрдөнө.

Хоёр. Нэр томъёо

- 2.1 Энэхүү гэрээг хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
 - (а) "Гэрээ" гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд байгуулсан бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
 - (б) "Гэрээний үнэ" гэж гэрээний дагуу бараа болон үйлчилгээний нийлүүлэгчид төлөх төлбөрийг хэлнэ.
 - (в) "Бараа" гэж нийлүүлэгчээс захиалагчид гэрээний дагуу нийлүүлэх эмнэлгийн хэрэгслийг хэлнэ.
 - (д) "Захиалагч" гэж барааг худалдан авч буй байгууллагыг хэлнэ.
 - (е) "Нийлүүлэгч" гэж гэрээнд заасан бараа, үйлчилгээг нийлүүлж байгаа байгууллагыг хэлнэ.
 - (ж) "Баталгаат хугацаа" эмнэлгийн хэрэгсэл, барааг зарлагын баримтаар хүлээлгэн өгсөн өдрөөс хойш гэрээнд заасан хугацааг хэлнэ.
 - (з) "Нийлүүлэх хугацаа" гэж гэрээнд заасан эмнэлгийн хэрэгслийг захиалагч талд хүлээлгэн өгөх хугацаа.
 - (и) "Ажлын талбай" гэж нийлүүлэх гэж буй барааны нөхцөлд нийцсэн, түүнийг хүлээж авахад тохиромжтой газрыг хэлнэ.
 - (й) "Хоног" гэж хуанлийн хоногийг хэлнэ.

Гурав. Гэрээ болон нийлүүлэлтийн хугацаа

- 3.1 Энэхүү гэрээг 2 талаас гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс хүчинтэйд тооцно.
- 3.2 Гэрээний хугацаа нь 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдөр хүртэлх хугацаанд нийлүүлнэ.
- 3.3 Нийлүүлэгч хоногт багтаан барааг захиалагч талд хүлээлгэн өгнө.
- 3.4 Нийлүүлэгч нь барааг аль болох түргэн шуурхай нийлүүлэх бүхий л арга хэмжээг авна.

Дөрөв. Төлбөр тооцоо

- 4.1 Нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ болон үнийг нийлүүлэгчийн үнийн жагсаалт, нэхэмжлэхийг баримтлан гүйцэтгэнэ.
- 4.2 Гэрээ хүчин төгөлдөр болсноор сар бүр нийлүүлэгчийн зарлагын баримтыг үндэслэн гэрээний санхүүжилтийн төлбөрийг “Сүвэн-Уул” ХХК-ийн Капитрон банкин дахь 3055001847 тоот дансанд шилжүүлнэ.
- 4.3 Гааль, татвар, эдийн засгийн байдал, үнэ ханшны өөрчлөлт болон бусад хүчин зүйлээс хамаарч үнэнд өөрчлөлт орвол нийлүүлэгч нь захиалагчид урьдчилан бичгээр мэдэгдэнэ.

Тав. Захиалагчийн эрх үүрэг

- 5.1 Нийлүүлэгч талд бараа нийлүүлэхэд шаардлагатай мэдээлтээр хангах буюу шаардлагатай мэдээллийг өгөх мэргэжлийн хүнтэй холбож өгнө.
- 5.2 Захиалгыг өөрийн байгууллагын нэр, хаяг, тамга бүхий захиалгын хуудсаар өгөх ба нийлүүлсэн эмнэлгийн хэрэгсэлийн захиалгыг хийж байх, барааны захиалгыг хийх бүрд тухайн үед нийлүүлэгчээс гаргасан үнийн саналын дагуу хийнэ.
- 5.3 Бараа хүлээн авах бэлтгэлийг хангах, хүлээн авах, хариуцан ажиллах ажилтныг томилох, барааг зарлагын баримтаар хүлээн авах.
- 5.4 Бараа тээвэрлэлт, нийлүүлэлтийн явцад гэрээний дагуу шаардлага тавих эрхтэй байна.
- 5.5 Захиалагч нь барааг хүлээн авах үед ажлын талбайг бэлэн болгосон байна.
- 5.6 Стандартын шаардлага хангаж буй эсэхийг шалгах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Захиалагч шалгалт, туршилт хийхээр томилсон төлөөлөгчийг нийлүүлэгчид бичгээр мэдэгдэх ба уг хүн нь барааны зарлагын баримтанд гарын үсэг зурна.
- 5.7 Нийлүүлэгч бараанд 1 жилийн баталгаат хугацаа өгнө.
- 5.8 Нийлүүлэгч нь барааны баталгаат хугацаанд гэмтэл согог хүлээн аваад гэрээний дагуу түүнийг арилгахгүй бол захиалагч өөрөө нийлүүлэгчийн зардлаар уг гэмтэл согогийг арилгах эрхтэй.
- 5.9 Гэрээгээр тохирсон хугацаанд нийлүүлэгчид төлбөрийг шуурхай барагдуулна.

Зургаа. Нийлүүлэгчийн эрх, үүрэг

- 6.1 Нийлүүлэх эмнэлгийн хэрэгсэл нь шинэ, урьд өмнө ашиглагдаагүй, гэмтэл согоггүй байх ба захиалагчид барааг гэрээнд тохирсон хугацаанд багтаан холбогдох бичиг баримтын хамт хүлээлгэн өгнө.
- 6.2 Нийлүүлэгч нь барааг худалдаж авах, тээвэрлэх, нийлүүлэх, хадгалах болон хүргэх үед гарч болох алдагдал, гэмтэлтэй холбоотой эрсдлээс хамгаална.
- 6.3 Гэрээний дагуу нийлүүлсэн эмнэлгийн хэрэгсэлд баталгаат хугацаа гаргахгүй.
- 6.4 Нийлүүлсэн эмнэлгийн хэрэгсэлд үйлдвэрийн гаралтай гэмтэл согог илэрвэл үнэ төлбөргүй

шуурхай сольж өгнө.

- 6.5 Бараа захиалсны дараа захиалагч талаас захиалганд өөрчлөлт оруулах тухай саналыг хүлээн авах боломжгүй тохиолдолд татгалзах, хүлээн авсан тохиолдолд нэмж гарах зардлыг нэхэмжлэн төлүүлнэ.
- 6.6 Захиалагч гэрээнд заасан хугацаанд гэрээний үнийн дүнг төлөхгүй тохиолдолд нийлүүлэгч барааг буцааж авах эрхтэй.

Долоо. Нууц хадгалах

- 7.1. Нийлүүлэгч нь бараа нийлүүлэхтэй холбогдон илэрхий болсон захиалагчийн бизнесийн нууцыг аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэгтэй.
- 7.2. Захиалагч нь нийлүүлэгч компанийн аливаа нууцыг хамгаалах үүрэгтэй бөгөөд барааны үнэ болон нийлүүлэлтийн нөхцөлийн талаарх мэдээлэл, бүтээгдэхүүний ашиглалтын заавар, нарийн мэдээллийг бусдад дамжуулахгүй байх үүрэгтэй.
- 7.3.

Найм. Бусад зүйл

- 8.1 Давтагдашгүй хүчин зүйл тохиолдсоны улмаас талууд үүргээ биелүүлээгүй бол хариуцлагаас чөлөөлөгдөнө.
- 8.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад үүссэн аливаа маргаантай асуудлыг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг урьтал болгох ба хэрэв тохиролцож чадахгүйд хүрвэл Монгол улсын хууль тогтоомжийн дагуу харьяалагдах шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 8.3 Аль нэг тал хуулийн этгээдийн хувьд өөрчлөгдсөн боловч үйл ажиллагааны чиглэл хэвээр байх тохиолдолд гэрээ цуцлагдахгүй. Энэ тохиолдолд талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 8.4 Гэрээ цуцлах тухай 7 хоногийн өмнө харилцан мэдэгдэж, төлбөр тооцоо дууссаны дараа албан ёсоор гэрээг цуцлаж акт үйлдэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн
Ерөнхий нягтлан бодогч

Д.Гантуяа

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн
Тоног төхөөрөмжийн албаны дарга

Ж.Баатар

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны
гудамж 13Б тоот

Нийлүүлэгчийг төлөөлж:

“Сүвэн-Уул” ХХК-ийн Ерөнхий нягтлан
бодогч

Б.Цэцгээ

“Сүвэн-Уул” ХХК-ийн Ерөнхий менежер,
тоног төхөөрөмжийн инженер

Г.Ганбаяр

Хаяг: Баянзүрх дүүрэг, 4-р хороо,
Энхтайвны өргөн чөлөө 46 тоот
Утас: 976-75756640
Факс: 976-77116640
И-мэйл: contact@suvn-uul.mn



СҮВЭН-УУЛ ХХК

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 4-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө 46

Утас: (976)- 75756640 Факс: (976)- 77116640

И-мэйл: contact@suvén-uul.mn, вэб: www.suvén-uul.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВД

2017.12.14 № 17/1163
танай _____-ны № _____-т

Үнийн санал хүргүүлэх тухай

Бид, та бүхний сонирхсон эмнэлгийн тоног төхөөрөмжид дараах үнийн саналыг хүргүүлж байна.

№	Бүтээгдэхүүний нэр	Үйлдвэрлэсэн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ (₮)	Нийт үнэ (₮)
	F1-21 Унтуулгын бодисны гаралт хэмжигч	Япон	1	5,000,000	5,000,000
Нийт үнэ (₮)					5,000,000

- Тус үнэд НӨАТ орсон.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



ШИШИНЭБААТАР

“НАЧИНХАЙРХАН” ХХК

2017 оны 12 сарын 13-ны өдөр

№ Ү-78.

Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВД

ҮНИЙН САНАЛ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

№	Бүтээгдэхүүний нэр	Үйлдвэрлэсэн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
	Унтуулгын бодисны гаралтыг хэмжигч аппарат	БНСУ	1	6,500,000	6,500,000
Нийт					6,500,000

ЗАХИРАЛ



Ө.АРИУНБОЛД

“ЭЙЧ ДИ ЭС ЮУ” ХХК

Эрүүл мэндийн хөгжлийн төв-д

Үнийн санал гаргах тухай

Дараах тоног төхөөрөмжид үнийн санал хүргүүлэв.

№	Тоног төхөөрөмжийн нэр	Үйлдвэрлэсэн улс	Үнийн санал /1 ширхэг/	Бэлэн байгаа эсэх	Нийлүүлэх хугацаа /нэмэлт захиалга/
1.	Унтуулгын аппаратны бодис хэмжигч аппарат	Австрали	7.900.000.0	Бэлэн	45 хоног
Нийт үнэ : 7.900.000.0					

Бидэнтэй хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Хүндэтгэсэн,



Захирал

С.Нарангарав

С.Нарангарав